



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/96

Булган сум

Зохицуулалт хийх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Бага, дунд боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/52 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/244 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц”-ийн 25 дахь долоо хоногийн даваа, баасан гарагийн анги танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулалт хийх хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Хичээл, сургалтын хөтөлбөрийн агуулга хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд бүрэн хэрэгжсэн байхаар зохион байгуулахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Ганболд)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай..

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



